



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

Бага тойруу 44, Засгийн газрын III байр,

Утас: 26-24-80, Факс: (976-11) 32-31-58

E-mail: info@mecs.gov.mn, http:www.mecs.gov.mn

2016. 08. 19 № 12/505

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого,  
боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын  
хорооноос 2016 оны 6/532 тоот бичгээр хүссэн  
боловсролын талаарх зарим мэдээллийг хавсарган  
хүргүүлж байна.

Хавсралт 29 хуудас.

Хүндэтгэсэн,

Ж. БАТСУУРЬ



9 0159

## БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ

### **Цэцэрлэгийн хүрэлцээ хангамж, 2016 оны барилга хөрөнгө оруулалт**

Монгол Улсын хэмжээнд 2015-2016 оны хичээлийн жилд нийт 1288 хүүхдийн цэцэрлэг ажилласан. Үүнээс төрийн өмчийн 826 цэцэрлэг, хувийн 462 цэцэрлэг ажиллаж байгаа нь өмнөх оноос 117 цэцэрлэг (төрийн 49, хувийн 68) нэмэгдсэн байна. (Хүснэгт 1).

Хичээлийн жил	Цэцэрлэгийн тоо	Өмчийн хэлбэр	
		Төрийн	Хувийн
2011-2012	879	734	145
2012-2013	945	750	195
2013-2014	1,067	764	303
2014-2015	1,177	777	394
2015-2016	1,288	826	462

Нийт цэцэрлэгийн 43.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод байгаа бөгөөд өмнөх оноос 1.6 пунктээр өссөн байна. Өнгөрсөн хичээлийн жилд өмнөх онтой харьцуулахад төрийн өмчийн цэцэрлэг 49, хувийн өмчийн цэцэрлэг 46-аар нэмэгдсэн.

2015-2016 оны хичээлийн жилийн байдлаар сургуулийн өмнөх боловсролд 225388 хүүхэд хамрагдсанаас 89,5 хувь болох 201834 хүүхэд цэцэрлэгт, 10,5 хувь болох 23554 хүүхэд хувилбарт сургалтын үйлчилгээнд хамрагдсан байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нийт хүүхдийн 31977 буюу 14.2 хувь нь малчдын хүүхэд байна. Мөн 1369 буюу 0.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 1868 буюу 0.8 хувь нь халамж эдэлдэг, 121 буюу 0.1 хувь нь бүтэн өнчин хүүхэд байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг жилээс жилд тогтвортой нэмэгдүүлж байна. Сургуулийн өмнөх боловсролд 2012 онд 180969 хүүхэд хамруулж байсан бол 2016 оны байдлаар 225388 хүүхдийг хамруулж үйлчилгээний хүчин чадлыг 44419 хүүхдээр нэмэгдүүлсэн.

Тус яам 2016-2017 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 2012 онтой харьцуулахад 61317 хүүхэд буюу 33,9 хувиар, 2015 онтой харьцуулахад 7,5 хувь буюу 16989 хүүхдээр нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Нэн ялангуяа, нийслэлийн цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, элсэлт, бүртгэлийг шуурхай зохион байгуулах талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай хамтран дор дурьдсан тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- 2016 онд ашиглалтад орох 3350 орны хүчин чадалтай 21 цэцэрлэгийн барилгыг аль болохоор хичээлийн жил эхлэхээс өмнө ашиглалтад оруулах, ашиглалтад орох хугацааг наашлуулах талаар холбогдох зохицуулалт, дэмжлэгийг зохион байгуулах,
- 2016 онд ашиглалтад орох 5 цэцэрлэг-сургуулийн цогцолбор тус бүрт цэцэрлэгийн 1 бүлгийг нэмж байгуулах, хүчин чадлыг нийт 120 ороор нэмэгдүүлэх,

- Ашиглалтгүй, сул суудалтай ажиллаж байгаа төрийн бус өмчийн 95 цэцэрлэгт 55 бүлгийг нээж, нийслэлийн цэцэрлэгийн хүчин чадлыг 3057 ороор нэмэгдүүлэх боломжийг судалж, холбогдох арга хэмжээг зохион байгуулах,
- Шинээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 2225 хүүхдийн хүчин чадалтай 44 төрийн бус өмчийн цэцэрлэг, 2100 орны хүчин чадалтай 37 цэцэрлэгт шинээр сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, улмаар 4446 ороор хүчин чадлыг нэмэгдүүлж, хичээл сургалтыг нь 9 дүгээр сарын 1-нээс эхлэхэд нь холбогдох дэмжлэгийг үзүүлэх;
- Цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн иргэн, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, шинжээчдийн дүгнэлт гаргах, барилгын нөхцөл нь хүүхдийн эрүүл, аюулгүй байдлын шаардлага хангасан нөхцөлд сургалт эрхлэх зөвшөөрлийг нөхцөлтэй олгох ажлыг шуурхай зохион байгуулж, хүчин чадлыг нэмэгдүүлэх,
- Цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийг зохион байгуулах комиссыг олон нийт, эцэг эх, хорооны нийгмийн ажилтан, багш, ажилтнуудын төлөөллийг оролцуулан байгуулах, цэцэрлэгт хамран сургах тойргийн хуульд заасан насны хүүхдийг хамруулах, иргэдэд мэдээллийг ил тод, нээлттэй байлгах, бүртгэл, элсэлтийг хүнд сурталгүй, шуурхай, найрсаг зохион байгуулах, хууль тогтоомжид зааснаас бусад хураамж, хандив авахыг хориглох;

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүчин чадал 2016-2017 оны хичээлийн жилд нийслэлд 11.8 хувиар буюу 11252 ороор, хөдөө орон нутагт 4.3 хувиар буюу 5646 ороор нэмэгдэнэ.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2016-2017 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 79.2 хувь /242286/, нийслэлд 73.1 хувь /106717/, хөдөөд 84.8 хувь /135569/ болно.

2016-2017 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд шинээр 62679 хүүхэд элсэхээс Улаанбаатар хотод 27579, хөдөөд 35100 хүүхэд элсэх урьдчилсан тооцоо байна.



#### Цэцэрлэгийн хүчин чадлыг өргөжүүлэх талаар

Улсын хэмжээнд 2016 он болон он дамжин баригдах 10405 орны хүчин чадалтай 105 цэцэрлэг, 7800 ор/14040 суудал бүхий цэцэрлэг, бага сургуулийн 78 цогцолборын барилга угсралтын төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. /Хавсралт 1a,b,c,d/

**Хүснэгт 1. БСШУ-ны салбарт 2016 онд хөрөнгө оруулалт хийгдэж буй барилга, байгууламжийн мэдээлэл**

Барилгын төрөл	Улсын төсөв		БНХАУ-ын		Японы		Концесс 2015 онд		Концесс 2016		Орон нутгийн төсөв		Нийт	
	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал
1 Цэцэрлэг	55	5965	1	100	9	1000	3	640	22	3700	15	2680	105	10405
2 Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор							72	Цэцэрлэг-7200 Сургууль-12960			6	Цэцэрлэг 600 Сургууль 1080	78	Цэцэрлэг 7300 Сургууль 13140

Улсын хэмжээнд 2016 ондоо багтаж нийт 5245 орны хүчин чадалтай 39 цэцэрлэг, 500ор/900 суудлын хүчин чадалтай 5 цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор ашиглалтад орно. /Хавсралт 2а,б,с/

**Улсын хэмжээнд 2016 онд ашиглалтад орох цэцэрлэг**

	Нийт			Улсын төсөв			Нийслэлийн төсөв			Японы тусламж		
	Тоо	Хүчин чадал	Төсөвт өртөг	Тоо	Хүчин чадал	Төсөвт өртөг	Тоо	Хүчин чадал	Төсөвт өртөг	Тоо	Хүчин чадал	Төсөвт өртөг
Цэцэрлэг	39	5245	30	16	1715	15.6	14	2580	5.4	9	950	9.0
Цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор	5	500 900	4.9				5	500 900	4.9			
Бүгд	44		34.9	16		15.6	19		10.3	9		9

Улаанбаатар хотод 2016 онд 3350 ор бүхий 21 цэцэрлэг, 500 хүүхдийн ор/900 хүүхдийн суудал бүхий цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор 5 ашиглалтад орно. Үүний үр дүнд нийслэлд цэцэрлэгийн орны тоог 3850-иар нэмэгдүүлнэ.

Сургуулийн өмнөх боловсролын насны хүн амын өсөлт

Сургуулийн өмнөх боловсролын насны хүн амын тоо сүүлийн жилүүдэд тогтвортойгоор нэмэгдэж байна. Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхэд 2012 онд 233291 байсан бол 2016 оны байдлаар 305744 болж 76,3 хувь буюу 72453 хүүхдээр нэмэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад сургуулийн өмнөх боловсролын насны хүүхэд 18.1 хувь буюу 12227 хүүхдээр нэмэгдсэн байна.



**Сургуулийн хүрэлцээ, хангамж,  
2016 оны барилга хөрөнгө оруулалт**

2015-2016 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 768 сургууль ажилласан. Тэдгээрийн 82.8 хувь нь төрийн өмчийн, 17.2 хувь нь хувийн сургууль бөгөөд нийт сургуулийн 72.0 хувь буюу 553 нь хөдөөд, 28.0 хувь буюу 215 нь нийслэлд байна. (Хүснэгт 1).

*Ерөнхий боловсролын сургуулийн тоо(өмчийн хэлбэр, ангилалаар)*

	Ерөнхий боловсролын сургууль							
	Бүгд	төрийн	хувийн	Бүгд	бага	дунд	ахлах	цогцолбор
2012-2013	755	621	134	755	55	138	515	47
2013-2014	756	628	128	756	61	130	522	43
2014-2015	762	628	134	762	62	136	514	50
2015-2016	768	636	132	768	62	118	538	50

2015-2016 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 546.2 мянган суралцагч суралцсан. Насан туршийн боловсролын төвд 10193 хүүхэд дүйцсэн хэлбэрээр суралцсан.

*Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид  
(сургалтын хэлбэрээр)*

	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид				
	Нийт	өдөр	Орой	эчнээ	дүйцсэн
2012-2013	509,792	496,123	617	1,242	11,810
2013-2014	510,203	497,022	588	973	11,620
2014-2015	517,878	506,816	315	680	10,067
2015-2016	546,215	535,055	244	723	10,193

2015-2016 оны хичээлийн жилийн байдлаар ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 94.2 хувь нь төрийн өмчийн сургуульд, 5.8 хувь нь хувийн өмчийн сургуульд суралцсан.

*Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (анги, өмчийн хэлбэрээр)  
Суралцагчдын тоо*

	Бүгд	Төрийн	Хувийн	Бүгд	Бага	Дунд	Ахлах
2012-2013	496,123	467,918	28,205	496,123	245,387	155,318	95,418
2013-2014	497,022	468,370	28,652	497,022	239,289	164,633	93,100
2014-2015	505,816	476,676	29,140	505,816	251,204	158,634	95,978
2015-2016	535,055	504,070	30,985	535,055	271,687	147,031	116,337

2015-2016 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 59.3 хувь буюу 317,2 мянга нь нэгдүгээр ээлжинд, 39.5 хувь буюу 211,5 мянга нь хоёрдугаар ээлжинд, 1.2 хувь буюу 6,3 мянга нь гуравдугаар ээлжинд хичээллэж байна. 3 ээлжтэй хичээллэж байгаа нийт 24 сургууль нийслэлд, 1 сургууль Хөвсгөл аймагт /Гурван эрдэнэ сургууль/ байна. Улаанбаатар хотод:

- Баянгол дүүрэгт 1 сургууль (73 дугаар сургууль),
- Сүхбаатар дүүрэгт 1 сургууль (71 дүгээр сургууль),
- Хан-Уул дүүрэгт 2 сургууль (115, 52 дугаар сургууль),

- Чингэлтэй дүүрэгт 3 сургууль (5, 21, 61 дүгээр сургууль)
- Сонгинохайрхан дүүрэгт 7 сургууль (9,62, 65, 76, 104, 107, 122 дугаар сургууль),
- Баянзүрх дүүрэгт 8 сургууль (14, 21, 33, 44, 84, 102, 111 дүгээр сургууль) байна.

### Бүлэг дүүргэлт

Улсын хэмжээнд бүлэг дүүргэлтийн дундаж 27.7 байгаа нь өмнөх жилээс 0.4 пунктээр, үүнээс төрийн өмчийн сургуульд 28.6 байгаа нь өмнөх жилээс 0.4 пунктээр, хувийн сургуульд 18.6 байгаа нь өмнөх жилээс 0.3 пунктээр тус тус өссөн байна. Бүлэг дүүргэлт нормативт хэмжээнээс дээгүүр буюу 36.9-46.9-тэй нэр бүхий нийслэлийн 25, аймгийн 1 сургууль байна Үүнд:

- Баянзүрх дүүрэг: 21 дүгээр сургууль (38.2), 33 дугаар сургууль(45.4), 44 дүгээр сургууль(36.9), 84 дүгээр сургууль(45.6), 111 дүгээр сургууль(42.2)
- Сонгинохайрхан дүүрэг: 12 дугаар сургууль (38.8), 104 дүгээр сургууль (37.3), Ирээдүй цогцолбор сургууль (37.0)
- Сүхбаатар дүүрэг: 1 дүгээр сургууль(47.7), 11 дүгээр сургууль (37.4), 2 дугаар сургууль (37.2), 31 дүгээр сургууль (41.6), 3 дугаар сургууль (38.9), 6 дугаар сургууль (37.1), 45 дугаар сургууль (38.6),
- Хан-уул дүүрэг: 18 дугаар сургууль(46.6), 52 дугаар сургууль (43.9), 114 дүгээр сургууль (39.6), 115 дугаар сургууль (38.1), Буянт-ухаа цогцолбор сургууль (40.8)
- Чингэлтэй дүүрэг:5 дугаар сургууль(43.9), 23 дугаар сургууль(51.2), 24 дүгээр сургууль(38.1),
- Баянгол дүүрэг: 93 дугаар сургууль (39.5), Эрдмийн өргөө цогцолбор сургууль (37.7)
- Өвөрхангай аймаг: Мэргэд сургууль (39.5) байна.

### Дотуур байрны хангалт

2015-2016 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 457 дотуур байр үйл ажиллагаа явуулж байгаагаас стандартын 321, стандартын бус 136 байна.

*Дотуур байрны тоо, хүчин чадал*

	Дотуур байр			Хүчин чадал
	Бүгд	Стандартын	Стандартын бус	
2012-2013	506	446	60	39,163
2013-2014	511	447	64	38,663
2014-2015	486	405	81	37,919
2015-2016	457	321	136	36,534

2015-2016 оны хичээлийн жилийн байдлаар 34,659 хүүхэд дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан байна. Нийт хүсэлт гаргасан суралцагчдын 95.9 хувь буюу 33253 хүүхэд дотуур байранд амьдарч байна. Хүсэлт гаргасан нийт хүүхдийн 70.8 хувь буюу 24536 нь малчдын хүүхэд байна. Хүсэлт гаргасан малчдын хүүхдийн 98.2 хувь буюу 24094 хүүхэд дотуур байранд орсон.

### Нэгдүгээр ангид шинээр элсэгч

2015-2016 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид 65,197 хүүхэд шинээр элссэн. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 7.7 хувиар өссөн бөгөөд суралцагчдын 94.4 хувь нь төрийн өмчийн, 5.4 хувь нь хувийн сургуульд элссэн. 2016-2017 оны хичээлийн жилд урьдчилсан тооцоогоор 69100 хүүхэд 1 дүгээр ангид элсэн орно. Үүнээс Улаанбаатар хотод 27629 хүүхэд элсэнэ.

### Сургууль, дотуур байр, спорт заалны хүртээмжийг нэмэгдүүлэх талаар

Улсын хэмжээнд 2016 он болон он дамжин баригдах 50412 суудал бүхий 92 сургууль, 7800 ор/14040 суудал бүхий 78 цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор, 2460 ор

бүхий 20 дотуур байр, 10 спорт заалны барилга угсралтын төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. /Хавсралт За,б,с,д/

БСШУ-ны салбарт 2016 онд хөрөнгө оруулалт хийгдэж буй барилга, байгууламжийн мэдээлэл														
Барилгын төрөл	Улсын төсөв		БНХАУ-ын тусламж		Японы тусламж		Концесс 2015 онд батлагдсан		Концесс 2016 онд батлагдсан		Орон нутгийн төсөв		НИЙТ	
	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал
2 Сургууль	67	34252	7	5760			7	6160	8	3280	3	960	92	50412
3 Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор							72	Цэцэрлэг-7200 Сургууль-12960			6	Цэцэрлэг 600 Сургууль 1080	78	Цэцэрлэг 7800 Сургууль 14040
4 Дотуур байр	16	1920							3	380	1	150	20	2450
5 Спорт заал	9										1		10	

Улсын хэмжээнд 2016 онд 9168 хүүхдийн суудалтай 22 сургууль, 500ор/900суудалтай 5 цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор, 6 спорт заал, 8 дотуур байр ашиглалтад орно. /Хавсралт 4а,б/

Улсын хэмжээнд 2016 онд ашиглалтад орох сургууль /тэрбум төгрөгөөр/									
Объектын төрөл	Нийт			Улсын төсөв			Нийслэлийн төсөв		
	Тоо	Хүчин чадал	Төсөвт өртөг	Тоо	Хүчин чадал	Төсөвт өртөг	Тоо	Хүчин чадал	Төсөвт өртөг
Сургууль	22	9168	54.8	20	8528	52.7	2	640	2.1
Цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор	5	500 900	500 900				5	500 900	4.9
Спорт заал	6	0	5.4	5		4.6	1		0.8
Дотуур байр	8	870	9.4	7	720	8.1	1	150	1.3
Бүгд	41		69.6	32		65.4	9		9.1

Улаанбаатар хотод 2016 ондоо багтаж 2560 суудалтай 6 сургууль, 500 ор/900 суудалтай 5 цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор, 1 спорт заал, 1 дотуур байр ашиглалтад орно.

#### Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Засгийн газраас сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгт хамруулах боломжийг бий болгохын тулд барих цэцэрлэгийн тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөдөө орон нутаг, малчдын хүүхдийн гэр цэцэрлэгийн нийлүүлэлтийг өсгөх, хувийн өмчийн болон байгууллагын цэцэрлэг байгуулах боломжийг өргөжүүлэхийн зэрэгцээ монгол орны онцлог, нөөц боломжид тулгуурласан үйлчилгээний болон санхүүжилтийн оновчтой шинэ арга, технологийг судлан хэрэгжүүлнэ.

Ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийн хувьд нэн тэргүүнд 3 ээлжийг арилгах, хүн амын өсөлт, суурьшил, нягтаршилтай уялдуулан эрэлт, хэрэгцээ хамгийн өндөр байгаа газруудад хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэх, хүчин чадлын ашиглалт, үр ашгийг оновчтой болгох бодлогыг хэрэгжүүлнэ.

#### **Сургууль, цэцэрлэгийн 2016 оны засварын хөрөнгө оруулалт**

Улсын хэмжээнд 6,8 тэрбум төгрөгийн өртөгтэй 89 засварын төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Засварын ажлын явц 8 дугаар сарын 15-ны байдлаар 82 хувьтай байгаа

бөгөөд 46 засварын ажил бүрэн дууссан бусад засварын ажил хичээл эхлэхээс өмнө дуусна.

Улаанбаатар хотод улсын төсвийн хөрөнгөөр 623,5 сая төгрөгийн өртөгтэй 7 төсөл арга хэмжээ, нийслэлийн хөрөнгөөр 169 сая төгрөгийн өртөгтэй 2 засварын ажил хэрэгжиж байна. Одоогийн байдлаар Баянгол дүүргийн 89-р цэцэрлэг, Сүхбаатар дүүргийн 45, 31-р сургууль, Хан-Уул дүүргийн 52-р сургуулийн засвар дууссан. Үлдэж байгаа Баянгол дүүргийн 88, 86-р цэцэрлэг, Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн барилга, Баянзурх дүүргийн Шавь цогцолбор сургууль, 21-р сургуулийн барилгын засварын ажлууд хичээл эхлэхээс өмнө дуусна.

### **Хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангахтай холбоотой төсөв санхүүгийн байдал**

Салбарын харьяа байгууллагууд болон орон нутагт өр, төлбөр хуримтлагдаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2015 оны төсвийн гүйцэтгэлээр түлш халаалтын нийт зардалд 9.9 тэрбум төгрөгийн өр үүсээд байна. Үүнээс орон нутгийн харьяа байгууллагын өр 5.0 тэрбум байгаа нь хичээлийн жилийн бэлтгэлийг хангахад бэрхшээл учруулж байна. Энэхүү өрийг барагдуулах талаар Сангийн яаманд уламжилж хамтарсан ажлын хэсгийг байгуулж, зарим аймаг, орон нутаг, байгууллагын нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан болно. Бүх аймгаас байгууллага нэг бүрээр тооцоо нийлсэн актыг гаргуулсан бөгөөд тус актаар 5.0 тэрбум төгрөгийн өр үүсээд байгааг баталгаажуулсан болно.

Салбарын харьяа байгууллагууд болон орон нутагт өр, төлбөр /сая төгрөгөөр/								
Байгууллага	НИЙТ ӨГЛӨГ	Үүнээс барагдуулах нэн шаардлагатай	Үндсэн цалин	Тэтгэврийн даатгал	Түлш, халаалт	Хоол, хүнс	Үндэсний тэтгэлэг, урамшуулал, бусад	Бусад
Орон нутаг	14,475.00	9,877.10	1,920.80	1,306.40	5,042.90	1,606.90	-	-
Ерөнхий боловсрол	11,020.60	7,298.60	1,609.30	1,146.80	3,555.40	987.2		
Соёл урлаг	1,388.70	1,153.70	55.5	40.3	1,057.80	-		
Сургуулийн өмнөх боловсрол	2,065.60	1,424.80	256.1	119.3	429.7	619.7		
Харьяа байгууллага	26,328.70	26,328.70	69.7	20.9	4,878.00	-	18,900.00	2,460.10
Сургалтын төрийн сан	18,900.00	18,900.00					18,900.00	
Их, дээд сургууль	4,744.70	4,744.70			4,744.70			
Яамны харьяа бусад байгууллага	545.9	545.9	69.7	20.9	133.3			322
Арга хэмжээний зардал	2,138.10	2,138.10						2,138.10
НИЙТ	40,803.70	36,205.80	1,990.50	1,327.30	9,920.90	1,606.90	18,900.00	2,460.10

### **Хоол, хүсний хангамж, аюулгүй байдал**

Бага боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, сурагчдын эрүүл мэндийг хамгаалах, сурагчийн суралцах идэвхийг өрнүүлэх зорилгоор 2006-2007 оны хичээлийн жилээс I-III, 2007-2008 оны хичээлийн жилээс I-IV, 2008-2009 оны хичээлийн жилээс I-V ангид “Үдийн цай”-ны үйлчилгээг нэвтрүүлсэн.

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын дагуу цэцэрлэгийн нэг хүүхдийн хоолны зардалд 1650-2400 төгрөг, дотуур байрын нэг хүүхдийн хоолны зардалд 2315 төгрөг, нэг хүүхдийн үдийн цайны зардалд 600 төгрөг тус тус зарцуулж байна.



2015-2016 оны хичээлийн жилд төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж буй 196639 хүүхдийн хоолны зардалд 40 тэрбум төгрөг, дотуур байранд амьдарч буй 33085 хүүхдийн хоолны зардалд 17 тэрбум төгрөг, бага ангийн 271687 хүүхдийн үдийн цайны зардалд 24,5 орчим тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган зарцуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн байршил, өмчийн хэлбэр, өрхийн орлого, эрүүл мэнд, иргэншлийн ялгаатай байдал зэргээс үл хамааран сургуульд суралцаж буй бага ангийн бүх сурагчид улсын төсвийн зардлаар үдийн цайны үйлчилгээг тэгш хүртэж байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын 80 гаруй хувь нь халуун хоол болон холимог байдлаар /халуун хоол, бэлэн бүтээгдэхүүнээр ээлжлэн үйлчилдэг/, 20 орчим хувь нь бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Мөн нийт сургуулиудын 40 орчим хувь нь буфетын үйлчилгээ эрхэлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг жил бүр улсын төсвөөс нийлүүлсээр байгаа хэдий ч улсын хэмжээнд зориулалтын гал тогоотой 350 гаруй сургууль, зориулалтын бус гал тогоотой 260 орчим сургууль, огт гал тогоо байхгүй 40 гаруй сургууль байна. Мөн орон нутгийн 130 орчим сургууль, нийслэлийн 100 орчим сургууль гал тогоог түрээслүүлэн ажиллуулж байна. Үүнээс: 150 гаран сургуулийн гал тогоог аж ахуйн нэгж, 80 орчим сургуулийн гал тогоог хувь хүн түрээслэн ажиллуулж байна.

Цэцэрлэг, сургуулийн хоол, хүнсний хангамжийн чанар, аюулгүй байдал нь зарим тохиолдолд хоол, хүнсний үйлдвэрлэл, аюулгүй ажиллагааны горим, технологид суурилагаасаа илүүтэй хүний сэтгэл, зүтгэл, хариуцлагаас хамаарсан байдалтай байна. Хоол, хүнсний аюулгүй байдал нь тогооч, эрхлэгч, захирал хэн байхаас хамаарахгүйгээр байнга мөрдөгддөг үйлдвэрлэлийн технологи, аюулгүй ажиллагаанд суурилсан байх шаардлага бий болж байна.

#### Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хоол, хүнсний аюулгүй байдлыг хангахад технологийн шаардлагыг хангасан хоол, хүнс боловсруулах орчинг бүрдүүлэх, зориулалтын гал тогоо, хоол, хүнс үйлдвэрлэлийн тоног, төхөөрөмж, хэрэгслийн хангамжийг сайжруулах нь чухал ач холбогдолтой байна.

Цэцэрлэг, сургуульд бүтээгдэхүүний гарал үүсэл, хугацаа нь тодорхой, чанар нь баталгаатай хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх, тээвэрлэлт, хадгалалтын технологи, горимыг мөрдөх, гал тогооны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, хоол, хүнсийг технологийн дагуу боловсруулах мэргэжлийн ур чадвар, хоол, хүнсийг боловсруулах эрүүл, аюулгүй ажиллагааны чадварт тогооч, гал тогооны ажилтнуудыг сургах, сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудыг хоол, хүнсний эрүүл, аюулгүй ажиллагаанд хяналт тавих арга чадварт сургах талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хоол, хүнсний үйлдвэрлэлийг эрүүл аюулгүй зохион байгуулдаг, эрсдлээс өөрийгөө урьдчилан сэргийлдэг, хамгаалдаг, аюулгүй ажиллагааны горим, технологид суурилсан хоол, хүнс үйлдвэрлэлийн технологийг бүх цэцэрлэг, сургуульд нэвтрүүлж, мөрддөг болгоно.

Сургууль, цэцэрлэгийн хоол, хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх аж ахуйн нэгжийг шалгаруулах, хоол, хүнсий үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааг хянахад олон, нийт, эцэг эх, багш сурагчдын бодитой оролцоог бий болгох нөхцлийг бүрдүүлнэ.

Цэцэрлэг, сургуулийн хоол, хүнсний хангамж, үйлдвэрлэл нь орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмждэг, сурагчдын амьдрах, аж төрөх ухаан, арга чадварыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг нэн ялангуяа хөдөө орон нутагт сургууль, цэцэрлэг чанартай, тэжээллэг, эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр өөрийгөө тогтвортой хангах бичил тогтолцоог бүрдүүлэхэд нь бодлогын дэмжлэг үзүүлнэ.

### ***Их, дээд сургуулийн хүртээмж, хүчин чадал***

2015-2016 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр Монгол Улсад дээд боловсролын 100 байгууллага сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо						
Өмчийн хэлбэр	2014-2015		2015-2016		Тооны өөрчлөлт (-бууралт)	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
	Бүгд	101	100	100	100	-1
Төрийн өмчийн	16	15.8	17	17	1	6.2
Төрийн бус өмчийн	80	79.2	78	78	-2	-2.5
Гадаадын салбар сургууль	5	5	5	5	0	0

2015-2016 оны хичээлийн жилийн эхэнд их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 162,626 болж, өмнөх хичээлийн жилээс 15,669-өөр буюу 8.8 хувиар буурлаа.

Суралцагчдын тоо төрийн өмчийн сургуульд 8,617-гоор буюу 8.3 хувиар, төрийн бус өмчийн сургуульд 6,957-гоор буюу 9.4 хувиар, гадаадын салбар сургуульд 95-аар буюу 23.1 хувиар тус тус буурчээ. Ийнхүү төрийн ба төрийн бус өмчийн болон гадаадын салбар сургуулиудад суралцагчдын тоо буурсан ч тэдгээрийн нийт дүнд эзлэх хувийн жин өнгөрсөн оныхоо түвшинд байна.

Нийт суралцагчдын 95033 буюу 58.4 хувь нь төрийн өмчийн, 67276 буюу 41.4 хувь нь төрийн бус өмчийн, 317 буюу 0.2 хувь нь гадаадын салбар сургуульд сурч байна.

Суралцагчдын тоо (сургуулийн өмчийн хэлбэрээр)						
Өмчийн хэлбэр	2014-2015		2015-2016		Тооны өөрчлөлт (-бууралт,%)	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
	Бүгд	178,295	100	162,626	100	-15,669
Төрийн өмчийн	103,650	58.1	95,033	58.4	-8,617	-8.3
Төрийн бус өмчийн	74,233	41.6	67,276	41.4	-6,957	-9.4
Гадаадын салбар сургууль	412	0.3	317	0.2	-95	-23.1

Салбарын 2015-2016 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр дотуур байранд суухаар нийт 11740 оюутан санал гаргасан байна. Үүнээс дотуур байранд амьдардаг

11058 оюутан байна. Дорх хүснэгтэд төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын оюутны дотуур байрны судалгааг үзүүлэв.

Дотуур байрны хүртээмж, төлбөрийн хэмжээ						
Сургууль	Хүчин чадал	Байрны тоо	Төлбөр /мян.төг/		Өссөн дүн	Өсөлтийн хувь
			2014	2015		
МУИС	1884	6	430	550	120	27.90%
ХААИС	900	4	410	460	50	12.20%
АШУУИС	1440	3	380	430	50	13.20%
ШУТИС	1400	4	350	400	50	14.30%
СУИС	200	1	379	417	38	10.00%
МУБИС	2500	7	320	386	66	20.60%
БХИС	300	1	Төлбөргүй			
ХСИС	850	1	Төлбөргүй			
ХБК	60	1	250	300	50	20.00%
1000 оюутныбайр	850	2	780	850	70	9.00%
НИЙТ	10384	30				
Дундаж			412.4	474.1	61.8	15.00%

### Сургалтын төлбөрийн хэмжээ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, иргэдийн аж байдал сайнгүй байгаатай холбогдуулан төрийн өмчийн их, дээд сургууль, коллежуудын сургалтын төлбөрийг 2016-2017 оны хичээлийн жилд нэмэгдүүлэхгүй байх талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Төрийн өмчийн их, дээд сургуулийн сургалтын төлбөрийн хэмжээ 2016-2017 оны хичээлийн жилд нэмэгдэхгүй, өнгөрсөн хичээлийн жилийн төлбөрийн хэмжээнд байна.

Төрийн өмчийн их, дээд сургуулийн төлбөрийн дундаж хэмжээ 0.9-2.8 сая төгрөг байна.

ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ СУРГУУЛЬ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА																	
д/д	Сургуулийн нэр	Бакалавр															
		1 дүгээр дамжаа				2 дугаар дамжаа				3 дугаар дамжаа				4 дүгээр дамжаа			
		1 кредит цагийн дундаж үнэлгээ/төг/			Дундаж төлбөр /сая төг/	1 кредит цагийн дундаж үнэлгээ/төг/			Дундаж төлбөр /сая төг/	1 кредит цагийн дундаж үнэлгээ/төг/			Дундаж төлбөр /сая төг/	1 кредит цагийн дундаж үнэлгээ/төг/		Дундаж төлбөр /сая төг/	
		2014 он	2015 он	Өссөн хувь		2014он	2015он	Өссөн хувь		2014он	2015он	Өссөн хувь		2014 он	2015 он		Өссөн хувь
1	МУИС	64300	81600	27,3	2,44	64300	72700	12	2,2	64300	72700	12	2,2	50300	56600	12,5	1,7
2	ХААИС	53300	66600	25	2,0	56600	66000	16,5	1,98	56600	66000	16,5	1,98	56600	66000	16,5	1,98
3	АШУУИС	60000	70000	16	2,85	56000	65000	16	2,47	56000	65000	16	2,47	55500	55500	0	2,0
4	ШУТИС	50000	58500	17	1,7	50000	58500	17	1,7	50000	58500	17	1,7	50000	58500	17	1,7
5																	
6	СУИС	42300	46600	10	1,4	42300	46600	10	1,4	42300	46600	10	1,4	42300	46600	10	1,4
7	МУБИС	55000	65000	18	1,95	48300	58000	20	1,74	48300	58000	20	1,74	48300	58000	20	1,74
8	БХИС	38000	43000	13	1,3	35000	40000	14,2	1,2	31600	36600	15,8	1,2	28300	33300	17,6	1,0
9	ХБК	27400	31400	14,5	0,95	27400	31400	14,5	0,95	27400	31400	14,5	0,95	27400	31400	14,5	0,95
	дундаж			17,6	1,82			15	1,7			15	1,7			13,5	1,55

**Сургалтын төрийн сангаас олгосон буцалтгүй тусламж, үндэсний тэтгэлэг, хөнгөлөлттэй зээл,**

Доорхи хүснэгтэд шаардлагатай мэдээллийг үзүүлэлт тус бүрээр 2014-2016 оны хугацаанд хамруулан үзүүллээ.

Сургалтын төрийн сангаас олгосон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, үндэсний тэтгэлэг										
Үзүүлэлт		2014 он			2015 он			2016 он		
		Батлагдсан төсөв	оюутны тоо	гүйцэтгэл	Батлагдсан төсөв	оюутны тоо	гүйцэтгэл	Батлагдсан төсөв	оюутны тоо	гүйцэтгэл
Дээд боловсролын сургалтын байгууллагад хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар суралцагчид	хөн.зээл	4,300.00	4421	1,384.40	1,500.00	1985	1,499.90	2,500.00	1839	567.7
	буц.тус	3,337.00	5088	6,584.50	8,130.70	5273	8,130.30	4,996.70	5415	5,686.10
	Дүн	7,637.00	9509	7,968.90	9,630.70	7258	9,630.20	7,496.70	7,254.00	6,253.80
Өндөр хөгжилтэй орны магистр, докторт суралцагчид		8,205.00	189	8,237.90	7,837.20	160	6,047.30	7,337.20	93	2,498.00
Гадаадын бакалаврт суралцагчдад		1,875.00	40	3,640.50	3,375.00	34	3,691.30	4,528.60	142	1,474.00
Дэлхийн шилдэг 100 их сургуульд суралцагчдад		9,500.00	86	6,187.50	14,500.00	147	10,631.70	11,500.00	77	2,941.10
ДҮН		25,080.00	4476	21,957.40	27,216.90	3026	21,875.00	25,452.70	845	7,116.50
Үндэсний тэтгэлэг		86,343.00	127475	84,922.30	34,809.90	51721	34,809.90	33,656.60	41345	13,873.50
Урамшууллын тэтгэлэг			31569		5,149.70	9621	6,965.60	-		
ДҮН		86,343.00	159044	84,922.30	39,959.60	61342	41,775.50	33,656.60	41,345.00	13,873.50

**“Сайн оюутан хөтөлбөр”-ийн хэрэгжилт**

Засгийн газрын 2016 оны 229 дүгээр тогтоолоор “Сайн оюутан” хөтөлбөр батлагдсан. Тус хөтөлбөрийг Төрийн банк, Хаан банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг арилжааны банкуудтай Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам 92/02/ГБ02-97, 91/03/496 тоот гэрээ байгуулан хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь дээд боловсролын байгууллагад суралцаж байгаа оюутны хариуцлагыг дээшлүүлж, түүний өрсөлдөх чадвар, сурах бололцоог нэмэгдүүлж, оюутны сургалтын төлбөрийн зээлийн нөхцөлийг сайжруулахад оршино. Хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлбөрт зориулан авсан цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдлийг шинэ нөхцөлтэй зээлд шилжүүлэх, оюутанд сургалтын төлбөрийн богино болон урт хугацаатай зээлийг 5 хувийн хүүтэйгээр олгохоор журамд тусгасан.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотын банк, Худалдаа хөгжлийн банкуудаас Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүсэлт, гэрээний төсөл ирүүлсэн.

Арилжааны банк, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Дээд боловсролын сургалтын байгууллагуудын “Сайн оюутан” хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх гэрээг хийж эхэлсэн. Одоогоор 40 гаруй их, дээд сургууль, коллеж гэрээг байгуулсан.

Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор дээрхи оролцогч банкуудад нийт 11.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 1 хувийн хүүтэйгээр арилжаалан тухайн банкуудад мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэсэн.

“Сайн оюутан” хөтөлбөрт 2016 оны 6 дугаар сар 25-ны байдлаар 30 гаруй оюутан сургалтын төлбөрийн зээлэнд хамрагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 8 дугаар сарын 9-ны өдрийн хуарладаанаар Сайн оюутан хөтөлбөрийг зогсоох шийдвэр гаргасан.

***Хувьсах зардлын дундаж норматив,  
санхүүжүүлэх аргачлалын тухай***

Монгол Улсын “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дах заалт, “Боловсролын тухай хууль”-ийн 40 дүгээр зүйлийн 40.2, 40.3 дахь заалтыг тус тус үндэслэн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хувьсах зардлын хэмжээг Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан.

Шинэчлэн мөрдөж буй хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлалд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын хууль эрх зүйн өөрчлөлт болон бараа үйлчилгээний зардлын үнийн өсөлтийг тусган боловсруулсан бөгөөд 2016 оны батлагдсан төсөвт нэмэлт зардлын эх үүсвэр шаардагдахгүй, батлагдсан төсвийн хэмжээнд багтахар тооцсон. Тус тогтоол нь 2017 оны төсвийн төлөвлөлт, хэрэгжилтэд мөрдөнө.

- *Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 75 дугаар тогтоолын 1 болон 6 дугаар хавсралтыг үндэслэн цалин болон ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлсэн болно. Харин бусад хувьсах зардлын хэмжээг нэмэгдүүлээгүй.*
- *Бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид зарцуулах хувьсах зардлын дундаж нормативыг багшийн цалин хөлс, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 15 хувиар, бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг 5 хүртэл хувиар нэмэгдүүлсэн. Ерөнхий боловсролын сургуульд бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд зарцуулах багшийн цалингийн зардлыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн тооцсон.*
- *Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 75 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад ерөнхий боловсролын сургуулийн багшийн албан тушаалын цалинг тогтоосны дагуу багийн сургуульд 683.1 мянган төгрөг, сумын сургуульд дунджаар 386.8 мянган төгрөг, аймгийн төвийн сургуульд дунджаар 354.9 мянган төгрөг, нийслэлийн сургуульд дунджаар 325.1 мянган төгрөг байхаар нэг хүүхдэд ногдох багшийн цалингийн нормативыг тооцоолсон.*
- *Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлыг Монгол Улсын 2016 оны батлагдсан төсөвт үндэслэн тооцож нэг хүүхдэд ногдох зардал дунджаар 21.3 мянган төгрөг болгон тооцоолсон. Хуучин тогтоолтой харьцуулахад бараа үйлчилгээний хувьсах зардал нь орон нутгийн сургуулиудын хувьд 2%-8%-иар нэмэгдсэн.*
- *Дотуур байранд амьдрах нэг хүүхдэд зарцуулах хувьсах зардлын нормативт цалингийн зардал, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 15 хувиар, бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг 5 хүртэл хувиар*

нэмэгдүүлсэн. Дотуур байрны цалингийн зардалд дотуур байрны хүмүүжүүлэгч багш, тогооч, туслах тогооч, манаач, жижүүр, үйлчлэгчийн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан үндсэн цалингаар тооцож олгодог нэмэгдэл, нэмэгдэл хөлсний хэмжээгээр тооцон төлөвлөхөд дунджаар 337.6 мянган төгрөг болж байна.

**Цэцэрлэг, сургуулийн багшийн цалинг цаашид нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Багш нарын цалин хөлс нь 2010 онд 12 хувь, 2012 онд 55 хувь, 2014 онд 15 хувиар нэмэгдсэн. Дорхи хүснэгтээр багшийн цалингийн бүтэц, дундаж цалингийн дүнг танилцууллаа.

Цэцэрлэг, сургуулийн багшийн цалин, хөлсний бүтэц												
Он	Байгууллага	Цалингийн сүлжээний дундаж	Мэргэжлийн зэрэг	Ур чадвар	Анги удирдах	Заах арга	Кабинет	Үр дүнгийн	Орон нутгийн нэмэгдэл	Дундаж нэмэгдэл	Сарын цалингийн дундаж /сүлжээгээр/	Өсөлтийн хувь /өмнөх оньхоос/
2015	Сургууль	550.4	41.3	41.3	27.5	13.8	13.8	34.4	27.5	199.5	749.9	-
	Цэцэрлэг	488.9	36.7	30.6	-	4.9	-	24.4	24.4	121	609.9	-
2014	Сургууль	550.4	41.3	41.3	27.5	13.8	13.8	34.4	27.5	199.5	749.9	15%
	Цэцэрлэг	488.9	36.7	30.6	-	4.9	-	24.4	24.4	121	609.9	
2013	Сургууль	478.6	35.9	35.9	23.9	12	12	29.9	23.9	173.5	652.1	-
	Цэцэрлэг	425.1	31.9	26.6	-	4.3	-	21.3	21.3	105.2	530.3	-
2012	Сургууль	478.6	35.9	35.9	23.9	12	12	29.9	23.9	173.5	652.1	55%
	Цэцэрлэг	425.1	31.9	26.6	-	4.3	-	21.3	21.3	105.2	530.3	
2011	Сургууль	309.1	23.2	23.2	15.5	7.7	7.7	19.3	15.5	112	421.1	-
	Цэцэрлэг	265.6	19.9	16.6	-	2.7	-	13.3	13.3	65.7	331.3	-
2010	Сургууль	309.1	23.2	23.2	15.5	7.7	7.7	19.3	15.5	112	421.1	12%
	Цэцэрлэг	265.6	19.9	16.6	-	2.7	-	13.3	13.3	65.7	331.3	
2009	Сургууль	237.8	17.8	17.8	11.9	5.9	5.9	14.9	11.9	86.2	324	-
	Цэцэрлэг	237.8	17.8	14.9	-	2.4	-	11.9	11.9	58.8	296.6	-
2008	Сургууль	237.8	17.8	17.8	11.9	5.9	5.9	14.9	11.9	86.2	324	-
	Цэцэрлэг	237.8	17.8	14.9	-	2.4	-	11.9	11.9	58.8	296.6	-

Тус яамны зүгээс багш, ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх, үнэлэмжийг дээшлүүлэх талаар байнга судалж, санал тавьж ажиллаж ирсэн. Цаашид багшийн ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх, үр дүнд суурилсан үнэлгээг боловсронгуй болгох, цалин хөлсийг тооцох журам, дүрмийг боловсронгуй болгоход анхааран ажиллана.

**Үдийн цай хөтөлбөр, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар**

Бага боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, сурагчдын эрүүл мэндийг хамгаалах, сурагчийн суралцах идэвхийг өрнүүлэх зорилгоор 2006-2007 оны хичээлийн жилээс I-III, 2007-2008 оны хичээлийн жилээс I-IV, 2008-2009 оны хичээлийн жилээс I-V ангид “Үдийн цай”-ны үйлчилгээг нэвтрүүлсэн.

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын дагуу цэцэрлэгийн нэг хүүхдийн хоолны зардалд 1650-2400 төгрөг, дотуур байрын нэг хүүхдийн хоолны зардалд 2315 төгрөг, нэг хүүхдийн үдийн цайны зардалд 600 төгрөг тус тус зарцуулж байна.

2015-2016 оны хичээлийн жилд төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж буй 196639 хүүхдийн хоолны зардалд 40 тэрбум төгрөг, дотуур байранд амьдарч буй 33085 хүүхдийн хоолны зардалд 17 тэрбум төгрөг, бага ангийн 271687 хүүхдийн үдийн цайны зардалд 24,5 орчим тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган зарцуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн байршил, өмчийн хэлбэр, өрхийн орлого, эрүүл мэнд, иргэншлийн ялгаатай байдал зэргээс үл хамааран сургуульд суралцаж буй бага ангийн бүх сурагчид улсын төсвийн зардлаар үдийн цайны үйлчилгээг тэгш хүртэж байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын 80 гаруй хувь нь халуун хоол болон холимог байдлаар /халуун хоол, бэлэн бүтээгдэхүүнээр ээлжлэн үйлчилдэг/, 20 орчим хувь нь бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Мөн нийт сургуулиудын 40 орчим хувь нь буфетын үйлчилгээ эрхэлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг жил бүр улсын төсвөөс нийлүүлсээр байгаа хэдий ч улсын хэмжээнд зориулалтын гал тогоотой 350 гаруй сургууль, зориулалтын бус гал тогоотой 260 орчим сургууль, огт гал тогоо байхгүй 40 гаруй сургууль байна. Мөн орон нутгийн 130 орчим сургууль, нийслэлийн 100 орчим сургууль гал тогоог түрээслүүлэн ажиллуулж байна. Үүнээс: 150 гаран сургуулийн гал тогоог аж ахуйн нэгж, 80 орчим сургуулийн гал тогоог хувь хүн түрээслэн ажиллуулж байна.

Цэцэрлэг, сургуулийн хоол, хүнсний хангамжийн чанар, аюулгүй байдал нь зарим тохиолдолд хоол, хүнсний үйлдвэрлэл, аюулгүй ажиллагааны горим, технологид суурилагаасаа илүүтэй хүний сэтгэл, зүтгэл, хариуцлагаас хамаарсан байдалтай байна. Хоол, хүнсний аюулгүй байдал нь тогооч, эрхлэгч, захирал нь хэн байхаас хамаарахгүйгээр байнга мөрдөгддөг үйлдвэрлэлийн технологи, аюулгүй ажиллагаанд суурилсан байх шаардлага бий болж байна.

## **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ**

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**  
/сая  
төгрөг/

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2016 онд санхүүжих	Гүйцэтгэгч компани
		Эхлэх	Дуусах			
XII.1.1.103	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 2 дугаар цэцэрлэг/	2013	2016	1,454.8	193.2	Навтгар хайрхан ХХК
XII.1.1.110	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Чүлуут сум/	2013	2016	1,137.1	76.9	Жунсон ХХК
XII.1.1.119	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар цэцэрлэг/	2013	2016	1,565.2	121.3	Болор арамба ХХК
XII.1.1.106	Цэцэрлэгийн барилга /Баянхонгор, Бөмбөгөр сум/	2012	2016	791.2	357.1	Хаш гоёо ХХК
XII.1.1.153	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Булган, Булган сум, 1 дүгээр цэцэрлэг/	2012	2016	1,340.2	300.2	Чин ван констаркшн ХХК
XII.1.1.13	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Говь-Алтай, Тайшир сум/	2013	2016	550.0	275.0	Шатат ХХК
XII.1.1.91	Цэцэрлэгийн барилга /Говь-Алтай, Бигэр сум/	2015	2016	1,034.6	534.6	
XII.1.1.92	Цэцэрлэгийн барилга /Говь-Алтай, Төгрөг сум/	2015	2016	950.0	650.0	
XII.1.1.93	Цэцэрлэгийн барилга /Говь-Алтай, Тонхил сум/	2015	2016	1,034.6	734.6	
XII.1.1.115	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Говьсүмбэр, Сүмбэр сум, 1 дүгээр цэцэрлэг/	2013	2016	1,001.4	140.2	Оточ ноёдууд ХХК
XII.1.1.82	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 15 дугаар баг, Мөнгирт хороо/	2015	2016	1,000.0	269.5	Наран Орд ХХК
XII.1.1.125	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Шарын гол сум/	2014	2016	1,000.0	255.5	Прогресс цамхаг ХХК
XII.1.1.12	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Дорноговь, Дэлгэрэх сум/	2012	2016	619.7	21.3	Баянмарз ХХК
XII.1.1.6	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баян-Уул сум/	2013	2016	1,592.7	546.4	"Сүхжин" ХХК
XII.1.1.83	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Дорнод, Хөлөнбуйр сум/	2012	2016	1,080.1	39.0	Сүхжин ХХК
XII.1.1.113	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн, 11 дүгээр цэцэрлэг/	2013	2016	1,348.9	259.2	АглутХХК
XII.1.1.137	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/	2011	2016	935.3	270.7	Чандмань тал ХХК
XII.1.1.11	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дундговь, Дэлгэрхангай сум/	2012	2016	858.4	579.2	Говь гурвансайхан ХХК
XII.1.1.89	Дэлхийн банкны Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл төсөл /монголын талын хөрөнгө/ /Дундговь, Дэрэн сум/	2011	2016	299.2	151.9	Бридж констракшн ХХК
XII.1.1.102	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Эрдэнэдалай сум/	2012	2016	1,084.7	51.6	Бум констракшн ХХК
XII.1.1.136	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дундговь, Гурвансайхан сум/	2011	2016	550.0	15.3	Мөнхийн үргэлжлэл ХХК
XII.1.1.10	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай сум, Богдын гол баг/	2014	2016	1,000.0	500.0	Бэрсүм ХХК
XII.1.1.17	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Завханмандал сум/	2014	2016	1,420.0	986.4	Арь констаркшн ХХК
XII.1.1.118	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Цагаанчулуут сум/	2012	2016	952.1	367.7	РСТХХК
XII.1.1.7	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/	2014	2016	1,250.0	950.0	Хялгант нуга ХХК
XII.1.1.105	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Өмнөговь, Цогт-Овоо сум/	2012	2016	858.8	177.4	Ти Би И ХХК
XII.1.1.109	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сүхбаатар, Мөнххаан сум/	2012	2016	1,637.1	416.5	Хөх хайрхан трейд ХХК
XII.1.1.114	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сүхбаатар, Асгат сум/	2013	2016	1,014.0	565.5	Аригун ХХК
XII.1.1.80	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Шаамар сум/	2012	2016	880.9	135.3	Цо Би А ХХК
XII.1.1.81	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/	2012	2016	786.6	84.9	Карголанд ХХК
XII.1.1.101	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/	2012	2016	771.2	293.0	Талын Монгол групп ХХК
